



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 17


Сүхбаатар сум


“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл,
нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 15 дугаар зүйлийн 15.6, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.”Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг жил бүр аймгийн төсөвт тусган шийдвэрлүүлж, удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтийг 2 жил тутам аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын
14-ний өдрийн 17 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГАА” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1. Хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27-32 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.6.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47-55, 70, 77-79 дүгээр заалт, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид тусlamж олгох нөхцөл, журам” зэрэг нь хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

1.2. Өнөөгийн байдал

2016 оны төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн дунгээр аймгийн хэмжээнд нийт 5993 төрийн албан хаагч, үүнээс улс төрийн албан хаагч-111, төрийн захиргааны албан хаагч-812, төрийн тусгай албан хаагч-427, төрийн үйлчилгээний албан хаагч-4643 ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй албан хаагчдын 34 хувь нь эрэгтэй, 66 хувь нь эмэгтэй албан хаагч байна.

Боловсролын хувьд доктор-1, магистр-131, бакалавр- 2515, дипломын дээд зэрэгтэй- 667, тусгай дунд- 863, бүрэн дунд- 1346, суурь боловсролтой- 415, бага боловсролтой-38, боловсролгүй- 17 хүн байна.

Төсвөөс жилд нийт 33192.2 сая төгрөгийг цалин хөлс, 4125.0 сая төгрөгийг шагнал урамшил тэтгэмж, тусlamжид олгож байна. Ажилтнуудын дундаж цалин 653.23 мянган төгрөг байна. Нийт төрийн албан хаагчдаас орон сууцны судалгааг авч нэгтгэхэд нийтийн орон сууцанд 913, хувийн орон сууцанд 1210, амины орон сууцанд 3489, гэрт 381 төрийн албан хаагч амьдарч байна.

2017 онд 398 төрийн албан хаагч орон сууцны зээлэнд хамрагдаж, 4877 төрийн албан хаагчид цалингийн зээлтэй байна.

1.3. Хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл нь төрийн бүх шатны байгууллага зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай хүний нөөцийн хүчээр хэрэгжүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээ үзүүлэхийг шаардахын зэрэгцээ тэдний ажиллах таатай орчин нөхцлийг сайжруулах, цалин хөлсийг хууль тогтоомжийн хүрээнд нэмэгдүүлэх асуудлуудыг зохицуулах зайлшгүй хэрэгцээтэй байна. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг

хангахад зориулж байгууллага бүр тодорхой хэмжээний хөрөнгө, мөнгө зарцуулдаг бөгөөд энэ харилцааг “Байгууллагын дотоод журам”-ын хэмжээнд хязгаарлагдмал байдлаар зохицуулахаас гадна Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж энэхүү хөтөлбөрийг боловсруулж байна.

Цаашид төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг жигд сайжруулж, нийгмийн асуудлыг үнэн зөв, бодит судалгаанд үндэслэн нээлттэй, ил тод шийдвэрлэх нь төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, идэвхи санаачлагатай ажиллуулах үндсэн нөхцөл болно гэж үзэж байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Хөтөлбөрийн зорилго

2.1.1.Төрийн зорилт чиг үүргийг чанартай, шуурхай хэрэгжүүлэх үүднээс төрийн албан хаагчийн ажиллах таатай орчин, урам зориг, хүсэл эрмэлзлэлийг бий болгоход чиглэгдсэн хөдөлмөрийн харилцаан дахь урамшуулал, идэвхжүүлэлтийн аргад тулгуурласан олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

2.2.1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн олговор, тусlamж, дэмжлэг, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгох;

2.2.2.Төрийн албан хаагчийн өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлж, орон байрны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.3.Төрийн албан хаагчийн ажиллах орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй нөхцлийг сайжруулах;

2.2.4.Төрийн албан хаагчийг эрүүл мэндээ хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

2.2.5.Төрийн албан хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах;

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.3.1.Хууль тогтоомжийн хүрээнд ажиллах;

2.3.2.Тэгш хүртээмжтэй байх;

2.3.3.Ил тод нээлттэй байх;

2.3.4.Бодитой, үр дүнтэй байх;

2.4.Хамрах хүрээ

2.4.1.Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй нийт төр, төсвийн байгууллагын албан хаагчдын хэмжээнд хэрэгжинэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.“Төрийн албан хаагчийн өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлж, орон байрны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд:

3.1.1.Өрхийн орлогоо нэмэгдүүлэх, хөдөлмөрөө хоршиж аж ахуй эрхлэхийг дэмжих;

3.1.2. Орон сууцны нөхцлөө сайжруулах, хувийн орон сууц барихад хөнгөлөлт үзүүлэх

3.1.3.“Хүүхэд бүр цэцэрлэгт” зорилтын хүрээнд албан хаагчдын хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгох;

3.1.4. Албан хаагчдыг зээл, тусlamж авах, татварын хөнгөлөлт эдлэхэд байгууллагаас холбогдох дэмжлэгийг үзүүлэх;

3.1.5. Албан хаагчдыг газар өмчлөх, эзэмших, ашиглахад туслалцаа үзүүлэх, байгууллага хамт олноороо зуслангийн газар авах, байр барихад бодлогын дэмжлэг үзүүлэх;

3.2. "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн олговор, тусlamж, дэмжлэг, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгох" зорилтын хүрээнд:

3.2.1. Хууль тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах;

3.2.2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэх;

3.2.3. Албан хаагчдын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгохоос гадна хууль тогтоомжид нийцүүлэн бусад хэлбэрээр урамшуулах;

3.2.4. Албан хаагчдад ээлжийн амралт, нөхөн олговор, тэтгэвэр тэтгэмж, зээл, буцалтгуй тусlamж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх;

3.3. "Төрийн албан хаагчийн ажиллах орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй нөхцлийг сайжруулах" зорилтын хүрээнд:

3.3.1. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил, чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах;

3.3.2. Орчин үеийн технологийг бий болгох, шинэ арга барилыг эрэлхийлж ажиллах;

3.3.3. Ажлын байрны тохижилт, шинэчлэлийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай зохион байгуулах;

3.3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

3.3.5. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл үйл ажиллагаанаас албан хаагчийг хамгаалах;

3.4. "Төрийн албан хаагчийг эрүүл мэндээ хамгаалахад дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд:

3.4.1. Албан хаагчдад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох;

3.4.2. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт үе шаттайгаар хамруулах;

3.4.3. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, албан хаагчдын дунд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулах;

3.4.4. Нарийн мэргэжлийн эмчийн хяналтад байнгын эмчлүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, асран халамжилдаг албан хаагчдад жилд нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.4.5. Байгууллага бүр ажлын байранд эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх

3.4.6. Байгууллага бүр ажлын байран дээр биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хугацаанд хийж хэвших, нийтийн биеийн тамираар хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.5. “Төрийн албан хаагчийг үр бүтээлтэй тогтвор суурьшилтай ажиллуулах” зорилтын хүрээнд:

3.5.1. Төрийн албан хаагчдыг хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд төрийн албанаас чөлөөлөхгүй байх;

3.5.2. Төрийн албан хаагчийн мэдлэг үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургаж хөгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

3.5.3. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

3.5.4. Төрийн албанд мерит зарчмыг баримталж ажиллах;

3.5.5. Албан хаагчдыг урт, богино хугацааны сургалтад хамрагдах, эрүүл мэндийн байдлын улмаас эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон үед чөлөө олгох, хуулийн хугацаанд ажлын байрыг хадгалах;

3.5.6. Төрийн албан хаагчдын сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

3.5.7. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт:

4.1. Хөтөлбөрийг 2018-2024 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ.

4.3. Хөтөлбөрийг бусад холбогдох төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг нийт төрийн байгууллагын удирдлагууд жил бүрийн үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

4.5. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний холбогдох заалтыг төсөвт байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусган хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт:

5.1. Улсын болон орон нутгийн төсөв

5.2. Байгууллагын төсөв

5.3. Нийгмийн хариуцлагын хүрээн дэх хувийн хэвшлийн санхүүжилт

5.4. Хандив тусламж, сайн үйлсийн аян

5.5. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр

Зургаа. Хүрэх үр дүн:

6.1. Төрийн албан хаагчид үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ажлын үзүүлэлт, хөдөлмөрийн бүтээмжид нь ахиц, өөрчлөлт гарна.

6.2.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангагдана.

6.3.Төрийн албан хаагчийн амьдрал ахуй, орон байрны нөхцөл дээшилнэ.

6.4.Төрийн албан хаагчийн цалин хангамж, төлбөрийн чадвар нэмэгдэнэ.

6.5.Төрийн албаны нийгэмд эзлэх байр суурь дээшилж, иргэдийн төрийн байгууллагад ажиллах идэвх, сонирхол нэмэгдэнэ.

6.6.Төрийн зорилт чиг үүргийг хэрэгжиж, үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1.Хөтөлбөрийн нэгдсэн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс боловсруулж, хэрэгжилт үр дүнд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

7.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан тайлагнана.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР